

ЯПОНЫ ЗӨӨЛӨН ХҮЧНИЙ БОДЛОГЫН МОНГОЛ ДАХЬ НӨЛӨӨ

(Монгол- Японы соёлын харилцааны жишээн дээр)

Б.САРАНЧИМЭГ

ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан

Товч агуулга

Олон улсын харилцааны нөхцөл байдал нарийн төвөгтэй, геополитикийн өрсөлдөөн ширүүсэж буй өнөө үед их гүрнүүдийн зөөлөн хүчний бодлогын үүрэг улам бүр нэмэгдэж, геополитик, улс төр, эдийн засгийн нөлөөллөө хүчирхэгжүүлэх үр нөлөөтэй арга хэрэгсэл болжээ. Ялангуяа хөгжиж буй Монгол Улсад ямар элементээр илэрч, ямар арга замаар хэрхэн хэрэгжиж байгааг судлах нь эерэг ба сөрөг нөлөөллийг тогтооход зайлшгүй судлах чухал сэдэв юм.

Энэ нь Японы зөөлөн хүчний бодлого Япон-Монголын соёлын харилцааны жишээн дээр хэрхэн хэрэгжиж байгааг тусгахыг оролдлоо.

Түлхүүр үгс: зөөлөн хүчний бодлого, Монгол-Японы соёлын харилцаа, "Күүл Жапан стратеги"

Монголын нэртэй эрдэмтэн докторууд Их гүрнүүдийн зөөлөн хүчний онол хийгээд хэрэгжүүлж буй арга хэрэгсэл, нөлөөллийн талаар сүүлийн жилүүдэд нэлээдгүй хөндөж байгаа нь сайшаалтай байна. Монгол Улсад энэ сэдвээр 2018 онд эрдэм шинжилгээний тусгайлсан хурал зохион байгуулагдаж, тус хурлын үр дүнгээс *"Олон улсын харилцаан дахь зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс судалгаа, дүн шинжилгээ"* (2021) хамтын бүтээл уншигчдын хүртээл болж, тус бүтээлд Монгол Улсын зөөлөн хүчний бодлогын тулгамдсан асуудалд дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ хийхийг зорьжээ. Мөн *"Зөөлөн хүчний бодлого: Монгол-Оросын харилцаа"* (2022 он) хамтын бүтээлд Монгол Улсад их гүрнүүдийн зөөлөн хүчний бодлого соёл, урлаг, боловсрол, цахим систем, ажил хэргийн харилцаа нөлөөллийн хэлбэрээр хэрхэн хэрэгжиж байгаа талаар Монгол дахь Оросын зөөлөн хүчний бодлоготой харьцуулсан судалгаа гарсан байна.

Нөгөө талаар Японы зөөлөн хүчний бодлогын тухай Каорү Коно¹-гийн өгүүлэлд Японы зөөлөн хүчний бодлогын үүсэл, хөгжил, хэрэгжүүлэх арга замын талаар тодорхой тусгасан байна. Нөгөөтээгүүр Японы зөөлөн хүчний бодлого Монголд хэрхэн нөлөөлж буй талаарх судалгаа хязгаарлагдмал байгаа учраас энэхүү судалгааг гуравдагч хөршийн хувьд цаашид дэлгэрүүлэн судлах шаардлагатай байна.

Дэлхийн II дайнаас хойш улс гүрнүүд ашиг сонирхлоо эдийн засгийн болон улс төрийн дарамт шахалтаар тулган хүлээлгэх нь хязгаарлагдаж эхэлснээр бусад улс орныг эдийн засаг, соёлын нөхөрсөг харилцаагаар талдаа татаж, ятган сэнхрүүлэх замаар дипломат зорилгодоо хүрэх тухай “Soft power” буюу “Зөөлөн хүч”-ний онол олон улсын харилцаанд түгсээр ирсэн. Энэхүү онол нь Харвардын Их Сургуулийн эрдэмтэн Жозеф Най²-гийн 1990 онд хэвлэгдсэн “Bound to lead: The Changing Nature of American Power” хэмээх номд анх дурдагдсан байдаг. Тэрээр “Зөөлөн хүч гэдэг нь хүсэж байгаа зүйлээ хүч, албадлага хэрэглэх бус зөвшилцөл, ятган итгүүлэх, татан дагуулалтаар олж авахыг хэлнэ”³ гэж тодорхойлсон байна.

Японы зөөлөн хүчний бодлогын үүсэл, хөгжлийн тухайд

Японы Зөөлөн хүчний бодлогын хэрэгжилтийг ярихаас өмнө түүний үүсэл, хэрэгжих болсон шалтгаан түүхэн нөхцөлийг цухас дурдъя.

Япон Зөөлөн хүчний хэрэгжих болсон шалтгаан түүхэн нөхцөл нь “Япон улс дэлхийн II дайнд ялагдсаны дараа, цэргийн хүчнээс татгалзаж, АНУ-ын бодлогын дагуу батлан хамгаалах хүчингүй ардчилсан орон болж, 1946 онд Үндсэн хуулиа баталж уг хуулийнхаа 9-р зүйлд “Дайн хийхээс татгалзах тухай” онцгойлон тусгасан байдаг.⁴ Харин 1954 онд өөрийгөө хамгаалах хүчин үүсгэн байгуулж энэ нь Япон улсын тусгаар тогтнол ба энх тайвныг хангах чиглэлээр үүрэг гүйцэтгэх болсон. Түүнээс хойш Япон улс цэрэггүй энх тайванч үзлийг баримталсаар ирсэн.⁵ 1977 оны 8-р сард Японы ерөнхий сайд Фүкүда Такэо Манила хотод айлчлах үеэр Фүкүдагийн номлолыг гаргасан. Уг номлолд “Япон улс энх тайвныг

¹ Каорү Коно “Япон улсын зөөлөн хүчний бодлогын тухайд” Олон улсын харилцааны байдал, төлөв ба Монгол Улс, SIRPA FORUM, УБ., 2016

² Joseph S. Nye Улс төр судлаач, неолиберал урсгалын төлөөлөгч, Б.Клинтоны засаглалын үед Тагнуулын Үндэсний Зөвлөлийн дарга, Батлан хамгаалахын яамны Олон улсын байдлын асуудал эрхэлсэн орлогч сайдаар ажиллаж байв.

³ Joseph S. Nye. “Bound to Lead: The Changing Nature of American Power”, (Basic Books, 1990), Chapter II,

⁴ 日本憲法9条, <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=321constitution>

⁵ Каорү Коно “Япон улсын зөөлөн хүчний бодлогын тухайд” Олон улсын харилцааны байдал, төлөв ба Монгол Улс, SIRPA FORUM, УБ., 2016 84-р тал

эрхэмлэх бөгөөд цэргийн их гүрэн болохгүйг мэдэгдэж, Зүүн өмнөд Азийн бүс нутгийн болон дэлхийн энх тайван ба хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулах, Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн орнуудтай улс төр, эдийн засгийн салбараас гадна нийгэм соёл зэрэг өргөн хүрээнд “Жинхэнэ андууд” мэт чин сэтгэлээр харилцах, харилцан итгэлцлийг тогтоон тус бүс нутгийн орнуудын нэгдмэл байдлыг бэхжүүлэхэд идэвхтэй туслалцаа үзүүлэх санааг илэрхийлсэн”. Энэ номлол нь өмнөх түүхийн цэргийн их гүрэн гэсэн олон улсын таагүй нэр, дүр төрхөөсөө салахад маш том ач холбогдол өгсөн бөгөөд Японы олон улсын харилцаан дахь зөөлөн хүчний бодлогын эх үндэс болсон гэж үздэг.⁶

Зөөлөн хүчний бас нэг онол нь зөөлөн хүчний сурвалжууд нь “**нөлөө**” болж чадах хүртэл эдгээр нь зөөлөн хүч биш юм гэсэн байдаг. Энэхүү онолыг Каорү Коно дахин өөр жишээгээр баталсан байдаг.

Японы Кацүшика Хокусай (葛飾北斎) хэмээх зураачийн “Үкиёэ” (浮世絵) нэрт зураг Францын зураачдын сонирхлыг татаж, улмаар тэд Үкиёэ зургийн хэв маягийг өөрсдийн бүтээлд тусгаж өгснөөр бусад оронд түгэн тархах болжээ. Үүнээс “Жапонизм” (Japonisme) хэмээх хандлага гарч ирсэн ажээ. 1862 оноос эхлэн Парис, Лондон, Вена хотод болж буй олон улсын үзэсгэлэнд Япон Улсын засгийн газраас өөрийн орны урлагийн бүтээлийг оролцуулах болсноор дэлхий нийтэд түгээн дэлгэрүүлсэн түүхтэй. Түүнчлэн 1925 онд “Гэнжигийн түүх” уран зохиолыг Английн Артур Валэй⁷ англи хэл рүү орчуулсан нь Японы соёлыг дэлгэрүүлэх нэг үндэс болсон⁸ гэж үздэг нь Өөрөөр хэлбэл дэлхийн орнуудад нөлөө үзүүлж эхэлсэн түүх нь онолын хувьд Мэйжигийн үе буюу XIX зууны сүүлээр эхэлсэн гэж үндэслэл ч бий. Тэгвэл Монгол Улсад энэхүү дэлхийн анхны роман гэж тооцогддог “Гэнжийн туульс” романаас сэдэвлэсэн “Эсрэг дурлал” хэмээх драмын жүжгийг 2012 онд Монгол Улсад УДЭТ-ын тайзнаа монгол найруулагч найруулан үзэгчдийн хүртээл болсоныг зөөлөн хүчний “**нөлөө**” гэж үзэх онолын үндэстэй юм.

1991 онд Японы парламентын Доод танхимын хуралдаанаар анх удаа зөөлөн хүчний нэр томъёо албан ёсоор ярьж эхэлсэн нь зөөлөн хүчний бодлогыг хууль эрх зүйн хүрээнд боловсруулах эхлэл тавигдсан байдаг.

Түүнээс хойш өнөөг хүртэл Японы зөөлөн хүчний нөлөөг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг идэвхжүүлэх талаарх сэдэв өргөжсөөр эдүгээ бүх яам, засгийн газрын түвшинд яригддаг сэдэв болжээ. 2009 оны 3-р сард Японы

⁶ Каорү Коно “Япон улсын зөөлөн хүчний бодлогын тухайд” Олон улсын харилцааны байдал, төлөв ба Монгол Улс, SIRPA FORUM, УБ., 2016 88-р тал

⁷ Arthur David Waley Түүний хамгийн гайхамшигтай, нөлөө бүхий орчуулгад “Хятад 170 шүлэг” (1918), “Япон шүлэг” (1919), Мурасаки Шикибугийн “Гэнжийн үлгэр” (1925–33) зургаан боть орчуулга багтсан нь одоог хүртэл хадгалагдан үлдсэн хамгийн эртний зохиолуудын нэг юм.

⁸ Каорү Коно “Япон улсын зөөлөн хүчний бодлогын тухайд” Олон улсын харилцааны байдал, төлөв ба Монгол Улс, SIRPA FORUM, УБ., 2016, 89-р тал

Засгийн газрын Оюуны Өмчийн Стратегийг Удирдах Төв “Япон брэнд стратеги” – зөөлөн хүчний аж үйлдвэрийг хөгжлийн гол хүч болгох нь” нэртэй тайланг гаргасан.⁹ Энд зөөлөн хүчний аж үйлдвэрийг нэгдүгээрт, “контент” буюу кино, нэвтрүүлэг, анимэ, манга, тв тоглоомоор, хоёрдугаарт, хоол хүнс, хувцасны загвар, дизайнаар тодорхойлон эдгээрийн хүчийг Японы эдийн засгийг хөгжүүлэх хүчин зүйлс болгох бодлого боловсруулсан.

2010 оны 6 сарын 8-нд Японы Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яаманд “Күүл Жапан стратегийн танхим”¹⁰ байгуулагдаж, уг танхим нь голдуу ардын соёлыг сурталчлах үйл ажиллагаа явуулж байсан. Ерөнхий сайд Шинзо Абэгийн хоёр дахь засгийн газар 2013 оны 1-р сард “Японы Эдийн засгийг сэргээхэд чиглэсэн онцгой эдийн засгийн бодлого”-ыг баталснаар “Күүл Жапан” стратегийг хэрэгжүүлэх компаниудад хөрөнгийн тусламж үзүүлэх, төр ард иргэд хамтран Японы бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад руу борлуулах санааг дэвшүүлж, “Күүл Жапан стратегийг дэвшүүлэх хурал” хуралдаж, тэргүүлэн ажиллах сайдыг 2 сарын дараа шуурхай томилсон Шинзо Абэ асаны энэхүү стратегийг эдийн засгаа сэргээхийн зэрэгцээ дотоод аж үйлдвэрээ хөгжүүлэх, мөн олон улсын харилцаан дахь нэр хүндээ өсгөн өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах боломж гэж үзсэн түүний алсын хараа байсан болов уу.

II дайны дараа 1950 оноос олон улсын кино наадмуудад Японы кино оролцон өндөр үнэлгээ авч, 1964 онд Токио хотод, түүнээс 13 жилийн дараа Саппород Олимпын наадам зохион байгуулагдаж, Олимпын наадамтай холбоотойгоор Японы дэд бүтэц, техник технологи хөгжиж цахилгаан бараа, цаашлаад зурагтын тоглоом дэлгэрэх болсон юм. Хүйтэн дайны дараагаар япон анимэ, кино, япон хоол, компьютер, зургийн аппарат зэрэг дэлхийд алдаршсан нь “Made in Japan” гэх өөрийн гэсэн өнгө төрхийг аль хэдийнээ бий болгож чаджээ.

Жишээ нь Toyota, Subaru, Nissan, Mitsubishi, Suzuki, Honda, Mazda, Izusu, электроникийн Sony, Hitachi, Toshiba, Sharp, Panasonic, JVC, Seiko, Fuji, Yamaha, Kenwood, NEC, Olympus, Casio, Nikon, TDK, Pentax, National (Panasonic-д нэгдсэн), Orion, Mitsubishi, Pioneer, Funai, Konica Minolta, Sanyo Aiwa (Sony-д нэгдсэн) компанийн брэндүүдийг нэн тэргүүнд дурдаж болно.

Японы зөөлөн хүчний бодлогыг идэвхтэй хэрэгжүүлж буй соёлын салбарын үйл ажиллагаа Японы талаарх сонирхлыг татан нэмэгдүүлэх, Японд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, Японы талаарх эерэг хандлагыг бий болгоход чиглэдэг.

Япон зөөлөн хүчний бодлого соёлоор дамжин хэрэгжиж байгаа гэж үзвэл Монгол, Японы соёлын харилцаанд тулгуурлан хэрхэн нөлөөлж буйг авч үзье.

⁹ 平成21年3月10日, 知的財産戦略本部, コンテンツ・日本ブランド専門調査会

¹⁰ Мөн тэнд

БНМАУ-ын Гадаад явдлын яамны хэлтсийн дарга Д.Цэрэндорж, Япон улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Цүгэ Итарү нар Улаанбаатар хотноо “БНМАУ Япон Улсын Засгийн газрын хооронд соёлын харилцаа тогтоосон тухай ноот бичиг”-ийг 1974 оны 9-р сарын 23-нд солилцох хэлбэрээр **“Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр”** байгуулагджээ.¹¹

Харилцан солилцсон адил утга бүхий ноот бичигт:

- Шинжлэх ухаан-техник, соёл урлаг, спортын байгууллагын төлөөлөгчид, мэргэжилтэн, аспирант оюутан болон дээрх салбарт ажиллаж буй хүмүүсийг харилцан солилцох;
- Кино урлаг, урлагийн тоглолт, лекц, уран бүтээл, гэрэл зургийн үзэсгэлэн зэрэг соёлын арга хэмжээг зохиох;
- Эрдэм шинжилгээний ажил хамтран хийхэд дөхөм үзүүлэх;
- Үзүүлэн таниулах, сонсох материал солилцох;
- Албан ёсны хэвлэл, мэдээллийн материал солилцох;
- Эрдэм шинжилгээний ажилд зориулсан хэвлэл, мэдээллийн материал солилцох зэрэг хамтын ажиллагаа хэрэгжүүлэхээр тусгажээ.¹²

Хэлэлцээр байгуулагдсанаас хойш хоёр орны хооронд жил бүрийн хамтын ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлж, харилцаа, хамтын ажиллагааны хүрээ өргөжин тэлж иржээ. Соёлын хэлэлцээрийн дагуу монгол, япон багш, оюутан, аспирант, судлаачдыг хоёр талдаа тогтмол хүлээн авдаг болж, соёл урлагийн салбарт ч хамтын ажиллагаа идэвхэжсэн нь боловсролын харилцаа ч өргөжин тэлэх үндэс болжээ.

Японы дуу бүжгийн хэсэг 1974 онд Улаанбаатарт тоглолт хийж, Монголын Ардын дуу бүжгийн чуулгын хэсэг 1978, 1984 онд Токиод болсон Азийн болон Японы ардын урлагийн наадамд оролцжээ. Хоёр орны сонгодог бүжгийн жүжигчид ч хэд хэдэн удаа харилцан тоглолт хийх зэргээр хамтын ажиллагаа солилцоо өргөжиж, урлаг спортынхон, эрдэмтэд судлаачид, соёлын зүтгэлтэн, сурвалжлагчдын харилцан үйл ажиллагаа тогтмолжиж уламжлал болсон билээ.¹³

1990-ээд онд манай улсад эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, гадаад бодлогын цоо шинэ нөхцөл бий болж, Япон улстай харилцах харилцаа шинэ дээд шатанд бүх талаар өргөжин тэлэх түүхэн эргэлтийн цаг үетэй золгосон юм.¹⁴

¹¹ Монгол ба Япон XX-XXI зуунд: “Туравдагч хөрш” ийн харилцааны түүх Ц.Батбаяр, 2022 он, 216-р тал

¹² Мөн тэнд


¹³ Монгол-Японы соёлын харилцааны хэлэлцээр, түүний түүхэн ач холбогдол” Б.Сэржав. Олон улс судлал сэтгүүл 2018 он №1(108)

¹⁴ Мөн тэнд

Тухайлбал 1990 онд Худалдааны хэлэлцээр, 1991 онд Найрамдал хамтын ажиллагааны гэрээ, 1993, 1994 онд Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулагдаж, 1996 онд Монгол-Японы дипломат харилцааг **“Иж бүрэн түншлэл”**-ийн түвшинд хөгжүүлэх зарчмыг тохиролцсон байдаг.

Монгол Улсад 1990 оноос улс төр, эдийн засаг нийгмийн өөрчлөлт гарч нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлэх болсноор Япон улсын зөөлөн хүчний бодлого Монгол Улсад хэрэгжих нөхцөл бүрджээ. “Японы өдрүүд”¹⁵ 1991 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо, 1997 оны 8 дугаар сард Улаанбаатар хотноо, 1998 оны 2 сард Монголын кино өдрүүд, 7 сард нь Монголын соёлын өдрүүд Япон улсад, 1999 оны 7 дугаар сард Монгол-Японы найрамдал, соёлын өдрүүд Улаанбаатар хотноо, 2000 оны 6-7 сард “Монгол-Японы найрамдал, соёлын шинэ мянганы баяр” Улаанбаатар хотноо, 2006 онд Их Монгол Улсын 800 жилийн ойг Япон улсад “Монголын жил”, 2007 онд Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг Монгол Улсад “Японы жил” болгон тус тус тэмдэглэсэн нь соёлын хамтын ажиллагааг идэвхжүүлж, японд элэгтэй монголчуудыг бий болгож, япон орныг сонирхох, япон хэл сурах, японы соёлд татагдах, японд мэргэжил эзэмших залуучуудыг өсөн нэмэгдэхэд ач холбогдлоо өгсөн.

Top Reasons for Studying Japanese



Created by Nippon.com based on data from the Japan Foundation.
Multiple answers were allowed.

nippon.com


Эх сурвалж: <https://www.nippon.com/en/japan-data/>

Япон хэл сурах шалтгааныг тодохойлоход мөн л доорх судалгааг явуулжээ. Японы аниме, манга, J-Pop, fashion-нд татагддаж байгаа нь залуусын япон хэл сурахад гол шалтгаан болж байна. Мөн Японы соёлын

¹⁵ “Монгол- Японы харилцаа он дарааллын товчоо 1972-2022” Олон улс судлалын хүрээлэн, УБ., 2022 он. Соёмбо принтинг хэвлэлийн газар

төвөөр дамжин японд суралцах залуучуудын тоо нэмэгдэж байна гэж үзэж байна. 2022 оны байдлаар дэлхийн 25 оронд, японы соёлыг түгээх, японд элэгтэй хүмүүсийг бий болгох соёлын төвүүд үйл ажиллагаагаа явуулж байна.

Top 10 Countries/Regions by Number of Japanese Learners



Created by Nippon.com based on data from the Japan Foundation. nippon.com

Эх сурвалж: <https://www.nippon.com/en/japan-data/>

Монгол Улсын хувьд 2002 онд Монгол-Японы төв үүд хаалгаа нээж, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нэртэйгээр үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна. Үүнээс улбаалан 2001-2021 онд японд суралцаж буй монгол оюутны тоог цуглуулан өсөлтийг харуулахыг зорив.

Энэ төвөөр дамжин хоёр улсын харилцаа өргөжин тэлж, соёл боловсролын хамтын ажиллагаа шинэ агуулга хэлбэрээр баяжсан нь доорх тоо баримтаас харж болно.



Эх сурвалж: <https://www.studyinjapan.go.jp/ja/statistics/zaiseiki/data/>

Тоо баримтаас харахад 2000-аад онд 544 монгол оюутан японд сурч байсан бол 2006 оноос 1000 давж, 2013 онд 1500-д хүрч, 2015 онд 2500-д хүрч 1000-аар өсөж, 2018 онд 3000 давжээ. 2019, 2020 онд Ковид-19 цар тахлаас үүдэлтэй буурсан үзүүлэлттэй байна. Хоёр улсын харилцаа гүнзгийрч байгаагаас гадна японд мэргэжил эзэмшиж, суралцах хүсэлтэй монгол оюутны тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгааг дээрх тоо баримтаас харж болохоор байна.

Монгол, Японы соёлын форумыг 1999 онд Токио хотод, улмаар ээлжит форумуудыг 2000, 2007, 2010, 2022 онуудад Улаанбаатар хотод тус тус зохион байгуулж “Монгол Улсын соёлын өвийн хадгалалт ба ашиглалт”, “Монголын түүхэн ном судар, баримтын хадгалалт ба ашиглалт”, “Биет ба биет бус соёлын өвийг хамгаалах”, “Монгол-Японы соёлын түншлэл хөгжлийн түүх”, “Монгол орны үлэг гүрвэлийн олдвор, олдворт газруудыг хамгаалан хадгалах”, “Соёлын өвийн сэргээн засварлалт, хадгалалт, хамгаалалт”, “Монголын сүм хийдийн түүхэн товчоо төсөл”, “Монголын археологийн дурсгалууд, тэдгээрийг хадгалж хамгаалах зарим асуудал”, “Нүүдэлчин ардын уран зохиол, хөшөө хадны бичээсний судалгаа”, “Соёлын менежмент”, “Урлагийн менежмент”, “Музейн менежмент”, “Соёлын өвийн менежмент”, “Орон нутгийн соёл, урлагийн менежмент” зэрэг маш олон асуудлуудыг хэлэлцэж байгаа нь Монголын өв соёлыг дэлхийд таниулахад японы туршлагыг нэвтрүүлэх боломж гэж хэлж болохоор ач холбогдолтой арга хэмжээ юм.¹⁶

Шинэ зууны гараанд 2001 онд Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр, 2002 онд Монгол Улсын соёл болон боловсролын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Японы Засгийн газраас үзүүлж буй тусламжийн тухай солилцсон ноот, 2003 онд Техникийн

¹⁶ “Монгол-Японы соёлын харилцааны түүхэн тойм” Б.Борбилмаа, Pax Mongolica № 2, 2017

хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдсан байна. Соёлын салбарын хамтын ажиллагаа тус хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны хөгжил дэвшилтэй уялдан улам өргөжиж, агуулга цар хүрээгээ тэлж гүнзгийрсээр 2010 оны 11 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Япон Улсад төрийн айлчлал хийх үеэр хоёр орны харилцааг цаашид шат ахиулан хөгжүүлэх тухай **“Стратегийн түншлэл”** байгуулахад чиглэсэн Монгол, Японы Хамтарсан мэдэгдэл”-д гарын үсэг зурсан.

Уг мэдэгдэлд

1. Өндөр дээд хэмжээний яриа хэлэлцээг идэвхжүүлэх.
2. Эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх.
3. Хүн солилцоо, соёлын харилцааг идэвхжүүлэх.
4. Бүс нутаг, глобал асуудлаар хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай тусгасан байна.¹⁷

Хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимжүүлж, иргэдийн харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2010 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн Япон Улсын иргэд манай улсад 30 хүртэл хоногийн хугацаанд визгүй зорчуулах шийдвэр гарсан. Харин Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын иргэдэд 3 хүртэлх жилийн хугацаатай (нэг удаа 15 хүртэлх хоног) “Богино хугацааны олон удаагийн виз” олгох шийдвэрийг 2015 оны 8 дугаар сарын 15-наас эхлэн мөрдсөн. Манай хоёр улс ерөнхийдөө эдийн засаг, бүтээн байгуулалт, соёл боловсрол талаараа илүү хамтарч ажилладаг. Мөн Монгол Улс нь түүхэндээ анх удаа Япон улстай эдийн засгийн түншлэл байгуулсан юм.¹⁸

Өнөөг хүртэл Соёлын салбарын хамтын ажиллагаа тус хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны хөгжил дэвшилтэй уялдан улам өргөжиж, агуулга цар хүрээгээ тэлж гүнзгийрсээр ирлээ. Сүүлийн жилүүдэд “хоёр орны хооронд иргэд, хүүхэд залуучуудын солилцоо, боловсрол, судалгаа шинжилгээний болон сэтгүүл зүйн салбарын хамтын ажиллагаа шинэ түвшинд дэвшиж, ялангуяа Монгол Улсын суурь бүрэн дунд боловсролын орчныг сайжруулах, манай улсын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаа өргөжин тэлж байгааг” **“Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)”**-т дүгнэн тэмдэглэжээ.¹⁹ Дунд хугацааны энэхүү хөтөлбөрт хоёр орны харилцааг 3 чиглэлээр голлон хөгжүүлэхээр заасны нэг нь **“Соёл, иргэд хоорондын харилцаа, хамтын ажиллагаа”** байхаар тусгасан юм. Энэ хөтөлбөрт хоёр улсын засгийн газар хүүхэд залуучуудын харилцааг гүнзгийрүүлэх, хоёр

¹⁷ Монгол-Японы соёлын харилцааны түүхэн тойм” Б.Боргилмаа, Pax Mongolica № 2, 2017

¹⁸ Мөн тэнд

¹⁹ “Монгол-Японы соёлын харилцааны хэлэлцээр, түүний түүхэн ач холбогдол” Б.Сэржав. Олон улс судлал сэтгүүл 2018 он №1(108)

улсын түүх, соёл, соёлын өв болон улс төр, эдийн засаг, нийгмийн байдлыг хоёр улсын ард түмэнд таниулан сурталчлах, судлаач сэтгүүлчдийг харилцан солилцох, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар дахь хүний нөөцийн солилцоог хөгжүүлэх, шинжлэх ухаан, техник технологи, соёл урлагийн салбарын хамтын ажиллагааг дэмжих бодлого баримтлахаар заасан байна.²⁰

2011 онд Японы соёлыг сонирхогчдын холбоо байгуулагдаж жил бүр японы соёлын өдрүүдийг зохион байгуулдаг үйл ажиллагаа нь дээр дурдсанчлан зөөлөн хүчний **"Нөлөө"** биеллээ олж байгаагийн илрэл гэж хэлж болохоор байна.

Эдгээр соёлын арга хэмжээнүүдийг Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөр дамжуулан хэрэгжүүлдэг. Тус төв нь 2002 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд Японы анимэйшн, уран сайхны кино, цэнгээнт, баримтат болон шинжлэх ухааны танин мэдэхүйн нэвтрүүлэг төлбөргүйгээр түгээж байгаа нь Японы Күүл Жапан бодлого амжилттай хэрэгжих хүчин зүйл төдийгүй, япон хэл сонирхогчдыг тоог нэмэгдүүлэх, япон орныг таньж мэдүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Монгол, Япон Засгийн газар хооронд соёлын хэлэлцээр байгуулсан нь **Иж бүрэн түншлэлийн харилцаа**-наас **Стратегийн түншлэлийн харилцаа, Эдийн засгийн түншлэл, Тусгай стратегийн түвшинд хүрч** шинэ шатанд хүрч хөгжих эрх зүйн үндэс болсон. Мөн хоёр ард түмний хооронд харилцан ойлголцол гүнзгийрэх, найрсаг хамтын ажиллагаа хөгжих үндсийг тавьж, улмаар Монгол-Японы харилцаа өнөөг хүртэл өргөжин тэлэх чухал суурь нөхцөлийн нэг байсаар ирсэнд түүний эерэг нөлөөлөл оршино.

Дүгнэлт

1974 онд соёлын хэлэлцээр байгуулагдаж, энэ хүрээнд соёлын харилцаанаас гадна тус хэлэлцээрийн хүрээнд боловсролын харилцаа давхар хөгжиж, Япон улсад боловсон хүчнээ бэлтгэх үндэс суурь тавигджээ.

"Японы соёлын өдөрлөг" энэ жил 10 дахь удаагаа, "Японы олон улсын Манга шагнал"-ын тэмцээн 17 дахь удаагаа, "Япон хэлний уран илтгэлийн тэмцээн" 9 дэх удаагаа тус тус зохион байгуулагдаж уламжлал болон тогтсон нь Япон орныг сонирхох, японы талаарх ойлголтоо улам гүнзгийрүүлэхийг хүсэж буй залуус жилээс жилд өсөн нэмэгдэж байгааг **"Зөөлөн хүчний бодлого"** амжилттай хэрэгжиж байгаагийн илрэл гэж үзэж байна.

²⁰ "Монгол-Японы соёлын харилцааны хэлэлцээр, түүний түүхэн ач холбогдол" Б.Сэржав. Олон улс судлал сэтгүүл 2018 он №1(108)

Монгол Улсын соёл, боловсролын салбар нь японы зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх чухал талбар болж, хоёр улсын соёл боловсрол дахь хамтын ажиллагаа нь улс төрийн харилцааг бэхжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн байгаа нь Япон улстай Тусгай стратегийн түншлэлд хүртлээ хөгжсөн шинэ шат гэж хэлж болно.

Цаашид өөрийн улсын соёлын үнэ цэнийг мэдэрч, дэлхийд Монгол Улсыг бүрэн төлөөлж чадахуйц соёлын бүтээгдэхүүн гаргаж ирэхэд Японы "Күүл жапан стратеги"-ийг судлах явдал нь Монгол Улсын "Шинэ сэргэлтийн бодлого", "Алсын хараа-2050"-ыг хэрэгжүүлэхэд туршлага болохуйц ихээхэн ач холбогдолтой судалгаа болно гэж үзэж байна.

Японы зөөлөн хүчний бодлогын нөлөөлөл Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл болж, эерэг нөлөөллийг авчирч байна.

Соёлын хэлэлцээр байгуулагдсанаас хамтын ажиллагааны үр дүнд Япон хүнийг таниулах нь монголчуудын оюун санаанд дайнаас үүдсэн үзэн ядалтыг арилгаад зогсохгүй япон хүний зарчимч, үнэнч шударга занг эрхэмлэх, япон хүнд итгэх явдал нь Жозеф Найгийн ятган сэнхрүүлэх замаар дипломат зорилгодоо хүрэх тухай *"Soft power"* буюу *"Зөөлөн хүч"*-ний онолыг баталж байна.

Зөөлөн хүчний бодлогын геополитикийн мөн чанарыг орхигдуулалгүй үндэсний аюулгүй байдлын үүднээс их гүрнүүдийн соёлын нөлөөнд уусахгүйгээр Монгол дархлааг хадгалж, сэрэмж өгөх үүднээс, цаашид энэ сэдэв тасралтгүй үргэлжлэх стратегийн амин чухал сэдэв байх болов уу хэмээн үзэж байна.

Ашигласан эх сурвалж

1. Joseph S. Nye (2004). Soft power: The means to success in world politics. Public affairs.
2. Зөөлөн хүчний бодлого: Монгол-Оросын харилцаа ОУСХ, УБ., 2022 он. Хэвлэлийн газар "Бэмби сан" ХХК
3. Олон Улсын харилцаан дахь зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс судалгаа, дүн шинжилгээ" УБ., 2021, Соёмбо принтинг
4. З.Бжезинский "Шатрын аварга хөлөг: Америкийн оройлол, геостратегийнх нь зайлшгүй шаардлага" УБ., 2022
5. "Монгол- Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага" Б.Сэржав. ОУС сэтгүүл. 2017Nº(107)
6. "Монгол-Японы харилцаа: ХХ зууны сүүлийн хагаст" Б.Сэржав 2003 он

7. Монгол-Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2014-2017),
8. Монгол-Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021),
9. "Монгол, Японы харилцаа он дарааллын товчоон (1972-2022)" Олон улс судлалын хүрээлэн, 2022 он. Соёмбо принтинг
10. "Монгол, Японы харилцаа баримт бичгүүд (1972-2022)" Олон улс судлалын хүрээлэн, УБ., 2022 он. Соёмбо принтинг
11. "Монгол-Японы соёлын харилцааны хэлэлцээр, түүний түүхэн ач холбогдол" Олон улс судлал сэтгүүл 2018 он №1(108)
12. Монгол ба Япон XX-XXI зуунд: "Гуравдагч хөрш"-ийн харилцааны түүх Ц.Батбаяр, 2022 он
13. "Монгол, Японы харилцаа: эрт, эдүгээ" 2001 он, Монгол- Японы харилцааг дэмжих нийгэмлэг. УБ хот
14. Бямбаханд Л. "Зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлсэн Азийн зарим орны туршлага, Монгол Улсын боломж". Стратегийн судалгаа, УБ., (2015) No 70.
15. Батболд Ш. "Зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс". Рах Mongolica сэтгүүл. 2016 No2.
16. "Монгол-Японы соёлын харилцааны түүхэн тойм" Б.Боргилмаа, Рах Mongolica № 2, 2017
17. <https://www.studyinjapan.go.jp/ja/statistics/zaiseki/data/>
18. <https://www.1212.mn/mn>
19. https://www.mn.emb-japan.go.jp/itprtop_mn/index.html